



SAIT POLYTECHNIC

КАЛГАРИ, КАНАД УЛС

1916 онд байгуулагдсан Сайд Политехникийн Дээд Сургууль нь төсвөөс санхүүждэг, магадлан итгэмжлэгдсэн сургууль юм. **Канад улсдаа политехникийн тэргүүлэгч дээд сургуулиар шалгарсан манай сургуульд дэлхийн 115 гаруй улс орноос оюутнууд ирж суралцдаг.** Сүүлийн үеийн техник хэрэгслээр тоноглогдсон оюутны хотхон маань байгалийн үзэсгэлэнт Роки нурууны ойролцоо, Ванкувер хотоос 1 цаг нисэх зайд орших сая гаруй хүн амтай Калгари хотод байрладаг. Алберта мужийн энэхүү орчин үеийн хот нь хамгийн олон үндэстнээрээ улсдаа дөрөвт ордог.

Манай сургууль мэргэжлээрээ байнга өсөн дэвшихэд чиглэсэн өндөр түвшний дээд боловсрол олгодог. Энд сурдаг 9,000 гаруй үндсэн оюутнуудын 850 гаруй нь гадаад оюутнууд байдаг. Канад улсад боловсрол эзэмших сонголт тань Сайд Политехникийн Дээд Сургууль яах аргагүй мөн.

САЙТ ПОЛИТЕХНИКИЙГ СОНГОХ 10 ШАЛТГААН

- Орчин үеийн техник хэрэгслээр бүрэн тоноглогдсон байгууламжуудад явагддаг практик сургалтуудад хамрагдах
- Ихэнх сургалтын хөтөлбөрийн хүрээнд цалинтай дадлага хийх
- 27 оюутнаас бүрдэх жижиг ангиуд
- Аюулгүй бөгөөд найрсаг уур амьсгалтай орчинд хичээллэх
- Дипломын зэрэг авсны дараа их сургуульд шилжин суралцах боломжтой
- Англи хэлний сургалтын хөтөлбөр
- Хичээлийн улирлын үеэр гадуур ажиллах зөвшөөрөлтэй
- Ажил хийх зөвшөөрөл нь сургууль төгссөний дараа 3 жил хугацаанд хүчинтэй хэвээр байдаг
- Сургуулийн дэргэд 2 оюутны дотуур байртай
- Хотын төв рүү хялбар очих боломжтой



INTERNATIONAL CENTRE
MA206, HERITAGE HALL
1301 - 16 AVENUE NW
CALGARY, ALBERTA, CANADA T2M 0L4
Утас: 1.403.284.8852
Факс: 1.403.284.7386
И-мэйл: international@sait.ca

Гадаадын бүх оюутнуудын хувьд Сайд Политехникийн Дээд Сургуульд сурч, шинэ газар амьдралаа төвхнүүлэхэд тань Олон улсын төвийн ажилтнууд маань дэмжлэг туслалцаа үзүүлдэг. Та оюутны хотхонд ажиллаж буй бүх үйлчилгээнд хамрагдах эрхтэй байна. Мөн, онгоцны буудлаас тосуулах, элсэлт бүртгэлд хамрагдах, сургалтын хөтөлбөр, соёл, эрүүл мэнд, орон байр (айлд ба оюутны байранд байрлах), ажил олох, сайн дурын ажил хийх боломжуудын талаар зөвлөгөө авах, сургалт мэргэжлийн чиглэл авах, оюутны болон ажлын зөвшөөрөл авах, шинэчлэхэд туслалцаа авах зэрэг үйлчилгээг авч болно! **Манай гадаад оюутнуудын зөвлөхүүдтэй international@sait.ca хаягаар холбоо барьж** аялалын төлөвлөгөө, сонирхсон асуулт, онгоцны буудлаас тосуулах эсэх, айлд байрлах хүсэлтэй байгаа эсэхээ мэдэгдэнэ үү.

ТУС СУРГУУЛЬД СУРАЛЦАХ ӨРГӨДӨЛ ГАРГАХДАА:

1. Бөглөсөн анкет
2. Бүрэн бус ба бүрэн дунд боловсролын гэрчилгээний албан ёсны хуулбар
3. Гэрчилгээний англи орчуулгын эх хувь (нотариатаар баталгаажуулах)
4. Диплом ба зэргийн дипломын хуулбар/хэрэв байгаа бол
5. Англи хэлний түвшинг тогтоох шалгалтын дүн (IELTS, TOEFL ibt, CLBA, CAEL)
6. Бүртгэлийн хураамж \$200.00 Канад доллар (нөхөж олгогдохгүй)
7. Тодорхой хөтөлбөрт хамрагдахад шаардлагатай бусад материалуудыг ирүүлнэ үү.

Анкетыг шуудангаар, факсаар, и-мэйлээр эсвэл биеэрээ ирж өгч болно. Өргөдөл гаргахдаа бүртгэлийн хураамжийг бэлнээр, баталгаат чекээр, Visa эсвэл MasterCard-аар төлж болно. Хураамжийг төлөөгүй тохиолдолд өргөдлийг хүлээж авахгүй болно. Дипломын албан ёсны хуулбарыг (англи хэл дээр хөрвүүлсэн байх шаардлагатай) бусад бичиг баримтын хамт аль болохоор түргэн хугацаанд ирүүлэх шаардлагатай. **Дэлгэрэнгүй мэдээллийг манай онлайн танилцуулгын хамт sait.ca дээрээс авна уу.**

АНГЛИ ХЭЛНИЙ ТЕСТ ШАЛГАЛТУУД	ШААРДАГДАХ БОСГО ОНОО
Англи хэлний шалгалт (TOEFL)	Интернет шалгалт (IBT) - 80, хэсэг тус бүрт 20 оноо
Олон улсын англи хэлний шалгалтын систем (IELTS)	хэсэг тус бүрт 6.0 оноо
Канадын англи хэлний шалгалт (CAEL)	нийт 60 оноо
Канадын хэлний түвшин тогтоох шалгалт (CLBA)	хэсэг тус бүрт 8.0 оноо

САЙТ ПОЛИТЕХНИКИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН 60 ГАРУЙ БАКАЛАВРЫН ЗЭРЭГ, ДИПЛОМ БА СЕРТИФИКАТЫН ХӨТӨЛБӨРҮҮД:

Нягтлан бодох бүртгэл – Газрын тос, хийн үйлдвэрлэл
Удирдлагын мэдээллийн менежмент
Агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн технологи
Агаарын хөлгийн засвар үйлчилгээний техникч
Архитектурын технологи
Программчилсан системийн инженерчлэлийн технологи
Автомашин засварын технологи
Нисэхийн электрон төхөөрөмжийн технологи
Бизнесийн удирдлагын бакалавр: Нягтлан бодох бүртгэл
Технологийн бакалавр: Газарзүйн мэдээллийн систем
Технологийн бакалавр: Газрын тосны инженерчлэл
Талх, нарийн боов хийх урлаг
Мэдээлэл цацах системийн технологи
Бизнесийн удирдлага
Бизнесийн удирдлага – Автомашин менежмент
Бизнесийн ухаан
Химийн инженерчлэлийн технологи
Химийн технологи
Иргэний инженерчлэлийн технологи
Мэдээллийн сүлжээний администратор
Шүдний эмчийн туслах
Дизель төхөөрөмжийн техникч
Дижитал график харилцаа
Цахилгааны инженерчлэлийн технологи
Электроник инженерчлэлийн технологи
Яаралтай тусламжийн эмнэлгийн ажилтан
Яаралтай тусламжийн эмнэлгийн техникч
Яаралтай тусламжийн технологи - сувилагч
Эрчим хүчний менежмент
Инженерчлэлийн дизайн ба боловсруулах технологи
Байгаль орчны технологи
Хайгуулын мэдээллийн технологи
Кино ба видео үйлдвэрлэл
Геоматик инженерийн технологи
Эрүүл мэндийн мэдээллийн менежмент
Зочин хүлээн авах үйлчилгээний менежмент
Мэдээллийн технологи
Тоног төхөөрөмжийн инженерчлэлийн технологи
Сэтгүүл зүй
Хууль зүйн туслах ажилтан
Номын сангийн мэдээллийн технологи
Машинист техникч
Махны үйлдвэрлэл ба менежмент
Механик дизайны технологи
Механик инженерчлэлийн технологи
Эмнэлгийн лабораторийн туслах ажилтан

INTERNATIONAL CENTRE

MA206, HERITAGE HALL

1301 - 16 AVENUE NW

CALGARY, ALBERTA, CANADA T2M 0L4

Утас: 1.403.284.8852

Факс: 1.403.284.7386

И-мэйл: international@sait.ca

Эмнэлгийн лабораторийн технологи
Эмнэлгийн баримт бичиг сийрүүлэгч/бичээч
Сүлжээний техникч
Шинэ мэдээллийн хэрэгслийн үйлдвэрлэл ба дизайн (хөдөлгөөнт дүрс)
Хор хөнөөлгүй туршилт хийх үндэслэл
Эрүүл амьдралын хэв маягт зориулсан тэжээл
Программист
Газрын тосны инженерчлэлийн технологи
Газрын тос бүхий газар нутгийн зохицуулалт
Эмийн санчийн туслах – жижиглэнгийн худалдаа
Эрчим хүчний инженерийн технологи
Боловсруулах ажиллагаа
Дамжуулах хоолойн боловсруулалт
Мэргэжлийн тогооч
Радио, телевиз ба мэдээлэл цацах хэрэгсэл
Төмөр замын кондуктор
Нөхөн сэргээх эмчилгээний туслах ажилтан
Ариутгалын ажилтан
Технологи дэд бүтцийн менежмент
Аялал жуулчлал
Гагнуурын инженерийн технологи

Мэдлэгийн түвшнээ дээшлүүлэх боломжтой хичээлүүд:

Математик, шинжлэх ухааны хичээлүүд (биологи, хими, физик), англи хэл, компьютерийн үндсэн мэдлэг, компьютерын гар дээр бичиж сурах, портфолио бий болгох зэрэг чиглэлийн курсууд ордог.

Англи хэлний хичээл: Англи хэл үндсэн хэл нь биш оюутнуудад англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх сургалтуудыг санал болгодог. **Англи хэлний мэдлэг нь дунд түвшнийх бөгөөд САЙТ их сургуульд суралцахад хангалтгүй** байгаа оюутнууд хамрагддаг. Сургалт эхлэхээс өмнө та Канадын хэлний түвшин тогтоох шалтгалтыг (CLBA) өгсөн байх ёстой. **Та САЙТ-ад хандахаас өмнө уг шалгалтыг өгөхөөр бүртгүүлсэн байх шаардлагатай ба хичээл эхлэхээс 2 долоо хоногийн өмнө ирж шалгалтандаа орох ёстой.** Англи хэлний хичээлүүд жилийн турш 8 долоо хоног тутамд явагддаг.

ТӨЛБӨР (БАГЦААГААР)

Үндсэн хөтөлбөр	семестр тус бүр \$5,500-\$7,000 Канад дол. (сургалтын хөтөлбөрөөс хамаарна)
Англи хэлний хичээл (ELF)	8 долоо хоногийн хичээл \$2,300 Канад дол.

САЙТ ПОЛИТЕХНИКИЙН ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦАХ ХҮСЭЛТЭЙ БАЙГААД ТАНХ ТААТАЙ БАЙНА! МАНАЙД ИРЖ СУРАЛЦААРАЙ!

TWITTER ДЭЭР МАНАЙ SAITISC-ТЭЙ ХОЛБОГДОНО УУ.

ӨНӨӨДӨР ХАНДАЖ БҮРТГҮҮЛЭЭРЭЙ!

sait.ca

